



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан ч 135.7 сая төгрөгийн хөрөнгийг хууль тогтоомж зөрчиж үр ашиггүй зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/15

Улаангом

Аудитын тайлан батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар 6.3.1, 6.3.3 дахь заалт, 10 дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан /УВА-2021/114/ШТА-НА/, төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар болон холбогдох бусад газруудад тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Б.Авирмэд нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ



0200100062

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	Товчилсон үгийн тайлал	5
Аудитын менежер М.Бат-Амгалан	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, Үндсэн мэдээлэл	6 8
Ахлах аудитор Б.Авирмэд	Бүлэг 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж хуваарилсан ч Өлгий суманд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.	9
Аудитор А.Нанжидмаа Р.Аюуш	1.1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн байна.	9
	1.2. ОНХС-аас 262.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу ирж, туслах үйл ажиллагааны орлогыг 31.1 сая төгрөгөөр давуулан бүрдүүлсэн байна.	11
2021 оны 6 дугаар сар	1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилалтыг хийсэн ч Өлгий суманд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.	11
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3721, 7045-3799 дугаарын утсаар харилцана уу.	Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөхдөө ОНХС-ийн үйл ажиллагааны журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүй, зориулалт бус зардал гаргасан байна.	15
	2.1. Өлгий, Сагил, Наранбулаг сумууд иргэдийн санал аваагүй 5 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.	15
	2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн бүрдэл хангалтгүй байна.	17
	2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зориулалт бус зардал гаргасан байна.	21
	2.4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 244.5 сая төгрөгийн 16 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	27
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3-р баг Аймгийн Засаг даргын тамгын газрын байр	Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	28
	3.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.	28
	3.2. ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд	29

	шатны байгууллагад хүргүүлсэн байна.	
	3.3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.	30
	Дүгнэлт	33
	Холбогдох байгууллагын санал	34
	Аудитын газраас өгөх тайлбар	37
	Зөвлөмж	38

Товчилсон үгийн тайлал:

1	ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
2	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
3	ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
4	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
5	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
6	СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
7	МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
8	НА	Нийцлийн аудит
9	ШТА	Шууд тайлагнах аудит
10	ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
11	ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
12	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
13	ОУБ	Олон улсын байгууллага
14	НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
15	АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
16	ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
17	ХШҮДАХ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
18	ЭМТ	Эрүүл мэндийн төв
19	ХО	Хөрөнгө оруулалт
20	АМХТЗ	Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл
21	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
22	НАТ	Нөөц ашигласны төлбөр
23	ХАА	Худалдан авах ажиллагаа
24	НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
25	БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
26	БТСГ	Биеийн тамир спортын газар
27	ЭМГ	Эрүүл мэндийн газар
28	БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
29	ГБХЗХГ	Гэр, бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
30	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
31	ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
32	ХЖТ	Хөгжимт жүжгийн театр

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/27, А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын төлөвлөгөөг үндэслэн Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд нийцлийн аудитыг хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв.

Үүнд:

- Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж тайлагнасан эсэх;

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, аймаг сумын ИТХ, ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, ХШҮДАХ, Орон нутгийн өмчийн газар, төсөвт байгууллагуудыг хамруулж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2020 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал зэргийг авч үзэв.

4. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудитын Тулгуур зарчим MNS6817-6:2020, Нийцлийн аудитын зарчим MNS6817-8:2020, МУЕА-ын 2020 оны А/106 тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, аудитын судалгаа хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас аймаг, сумын төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар болон бусад хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлага, зөвлөмжид дурдагдсан зөрчлийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Нийцлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулж, чанарын хяналтыг хэрэгжүүлэн, багийг ахлах аудитор Б.Авирмэд ахалж, аудитор А.Нанжидмаа, Р.Аюуш нар төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудит хийх явцад тохиолдсон хүндрэл

Аудит хийх явцад аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/250, 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/293 дугаартай захирамж, Улаангом сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/162 дугаар захирамжаар аймаг, сумдад ковид-19 цар тахал тархсаны улмаас хөл хорио тогтоож, орох гарах хөдөлгөөнийг хязгаарласан тул аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг нүдээр үзэж, ажлын зураг авалт хийж зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай харьцуулж шалгах боломжгүй байсан.

Иймд холбогдох баримтад тулгуурлан хариуцсан албан тушаалтантай утсаар болон цахимаар уулзалт хийж, гүйцэтгэсэн ажлуудын фото зургийг аудитад хамрагдагч байгууллагуудаас авч, хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлд тусгасан байдлыг холбогдох нотлох баримтаар баталгаажуулан авлаа.

Цар тахлын дэгдэлтээс шалтгаалан хөл хорио тогтоож, сумаас орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж байсан тул баримт, материал хүлээн авахад хугацаа алдах, илэрсэн алдаа зөрчлийг холбогдох албан тушаалтанд танилцуулж шийдвэрлэх процесс удаашралтай байсан.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолд “Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10/04 дүгээр тоот тогтоолоор аймгийн ОНХС-д 3663.3 сая, урсгал зардалд 439.9 сая, өмнөх оны үлдэгдэл 220.0 сая, сумдын ОНХС-д 2253.6 сая, нийт 6576.8 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор батлагдсан 5570.7 сая төгрөгөөс аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-д 3063.2 сая, урсгал зардалд 439.9 сая, сумдын ОНХС-д 2067.5 сая төгрөгийг хуваарилж өмнөх оны үлдэгдэл 68.0 сая төгрөгийг нэмж нийт 5638.6 сая төгрөгөөр төлөвлөж тодотгон баталсан байна.

Бүлэг: 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан ч Өлгий суманд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

1.1. Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг хууль журамд заасны дагуу төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн санд ОНХС-аас анх 6356.8 сая төгрөг, тодотголоор 5570.7 сая төгрөгийн эх үүсвэр олгохоор төлөвлөн баталсан байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн 2020 оны тодотгосон төсөв

Хүснэгт-1 /сая.төг/

Аймаг	Дотоодын НӨАТ	Газрын тосны НАТ	АМНАТ	АМХТЗ	Урамшуулал	Дэмжлэг	Нийт
Увс	1482.4	245.4	2748.2	481.6	307.9	305.2	5570.7

Эх сурвалж: /Сангийн яамны 2020 оны 4-1/5768 тоот албан бичиг/

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө”, 6.2 дахь хэсэгт “Сум, дүүргийн Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө” гэж заасан байна. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр
- Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр
- Тухайн орон нутгийн орлогыг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив тусламж

Аймаг, сумдын ИТХ-аар 2020 оны тухайн шатны төсвийг батлахдаа Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, санхүүжих төсөл арга хэмжээг тодорхой тусгасан байна.

ОНХС-ийн хөрөнгийг аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 10/04 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-д 3663.3 сая, урсгал зардалд 439.9 сая, өмнөх оны үлдэгдэл 220.0 сая, сумдын ОНХС-д 2253.6 сая, нийт 6576.8 сая төгрөгөөр баталжээ.

Төсвийн тодотголоор батлагдсан 5570.7 сая төгрөгөөс аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-д 3063.2 сая, урсгал зардалд 439.9 сая, сумдын ОНХС-д 2067.5 сая төгрөгийг хуваарилж өмнөх оны үлдэгдэл 68.0 сая төгрөгийг нэмж нийт 5638.6 сая төгрөгөөр төлөвлөж тодотгон баталсан байна.

Дээрх тогтоолоор аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХНС-аас олгох санхүүжилт 3063.2 сая, өмнөх оны үлдэгдлээс 68.0 сая, нийт 3131.2 сая төгрөгөөр баталжээ.

Харин сумдын ИТХ ОНХС-ийн эх үүсвэрээ ОНХНС-аас хуваарилагдсан 2067.5 сая, өмнөх оны үлдэгдэл 571.4 сая, бусад эх үүсвэрээс 127.6 сая, нийт 2766.5 сая төгрөгөөр төлөвлөж баталсан байна.

Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-2 /сая.төг/

№	Сумын нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас батлагдсан дүн /тодотголоор/	Дотоод гадаадын хандив, тусламж болон бусад	Нийт
1	Баруунтуруун	0.00	96.3	-	96.3
2	Бөхмөрөн	21.4	104.5	4.4	130.3
3	Давст	15.86	97.9	-	113.8
4	Завхан	14.50	79.5	50.0	144.0
5	Зүүнговь	22.30	91.9	-	114.2
6	Зүүнхангай	12.78	110.8	22.2	145.8
7	Малчин	13.50	75.3	9.9	98.7
8	Наранбулаг	55.5	197.9	21.0	274.4
9	Өлгий	6.6	67.0	-	73.6
10	Өмнөговь	10.3	89.7	-	100.0
11	Өндөрхангай	26.8	154.4	-	181.2
12	Сагил	3.4	52.9	-	56.3
13	Тариалан	88.5	93.7	2.7	184.9
14	Түргэн	25.3	61.3	-	86.6
15	Тэс	84.5	106.7	-	191.2
16	Ховд	12.3	63.1	6.0	81.4
17	Хяргас	60.4	105.5	-	165.9
18	Цагаанхайрхан	77.9	111.1	-	189.0
19	Улаангом	19.6	308.0	11.4	339.0
Сумдын дүн		571.4	2,067.5	127.6	2766.5

Эх сурвалж: /Сумдын ИТХ-ын тогтоолууд/

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөгөөг графикаар харуулбал:



Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

1.2. ОНХНС-аас 262.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу ирж, туслах үйл ажиллагааны орлогыг 31.1 сая төгрөгөөр давуулан бүрдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэгт “ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ” гэж заажээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь;

ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр хуульчлагдсан дээрх нэр төрлийн орлогууд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэгт багтаж байгаа бөгөөд аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг дараах байдлаар төлөвлөж бүрдүүлсэн байна.

Хүснэгт-3 /сая.төг/

№	Орлогын нэр төрөл	Аймаг		Сум	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	ОНХНС	3063.3	2885.09	1454.4	1370.2
2	ОУ-ын төсөл хөтөлбөрөөс олгох дэмжлэг, урамшуулал			613.1	613.1
3	Үйл ажиллагааны орлого			127.6	158.7
4	Өмнөх оны үлдэгдэл	68.0	68.0	571.4	571.4
5	Урсгал зардал	439.9	439.9	0	0
	Нийт дүн	3571.2	3542.9	2766.5	2713.4

Эх сурвалж: /Увс аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн алба/

ОНХНС-аас гүйцэтгэлээр 262.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу ирснээс шалтгаалж аймгийн ОНХС-д 178.1 сая, сумдын ОНХС-д 84.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Харин сумууд өмнөх онд бэлтгэсэн өвс, тэжээлийг худалдан борлуулж нийт 127.6 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөж тайлант хугацаанд 158.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь төлөвлөснөөс 31.1 сая төгрөгөөр орлогыг давуулан биелүүлсэн байна.

1.3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилалтыг хийсэн ч Өлгий суманд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.1 дэх заалтад “Энэ хуулийн 60.11-д заасан үйлчилгээний зардалд ногдох хэсгийг сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлэх” гэж заасны дагуу “Улаангом тохижилт үйлчилгээ” орон

нутгийн төсөвт үйлдвэрийн газарт 40.9 сая, мал эмнэлгийн үйлчилгээнд 398.9 сая, нийт 439.9 сая төгрөгийг ОНХС-ийн эх үүсвэрээс урсгал зардалд хуваарилж зарцуулсан байна.

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулиар ОНХС болон улсын төсвөөс Увс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн 5570.7 сая төгрөгийг дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт-4 /сая.төг/

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн
1	НИЙТ ДҮН	5570.7
2	ОУ-ЫН БАЙГУУЛЛАГААС СУМДАД ОЛГОХ ДЭМЖЛЭГ, УРАМШУУЛАЛ	613.1
3	УРСГАЛ ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ	439.9
4	АМНАТ	574.6
5	ИТГЭЛЦҮҮРЭЭР ХУВААРИЛСАН ДҮН	3943.1

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дэх хэсэг “Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна”, 59.2.2 дахь заалтад “Энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 30-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах” гэж заасны дагуу ОНХС болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийн 30 хувийг сумдын ОНХС-д хуваарилсан байна.

Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилсан байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт- 5 /сая.төг/

№	Үзүүлэлт	1. Хүн амын тооноос хамаарах		2. Алслалтаас хамаарах		3. Нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах		Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн	Тогтвортой амьжиргаа 3 төсөл		2020 онд олгох нийт дүн
		Хүн амын тоо	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн /40%/	Алслалтын индекс /2011/	Алслалтаас хамаарсан /30%/	Газар нутаг	Газар нутгаас хамаарсан /30%/		дэмжлэг	Урамшуулал	
1	Баруунтуруун	2700	15.47	193	24.74	3300	16.82	57.02	14.71	24.16	96.75
2	Бөхмөрөн	2284	13.08	174	18.86	3700	18.86	50.81	13.10	21.52	123.62
3	Давст	1703	9.76	136	10.99	6300	32.11	52.86	13.64	22.39	106.99
4	Завхан	1843	10.56	161	14.08	6800	34.66	59.30	15.30		84.47
5	Зүүнговь	2778	15.91	139	18.33	4000	20.38	54.63	14.09	23.14	91.86
6	Зүүнхангай	2305	13.20	357	39.06	2600	13.25	65.52	16.90	27.75	111.47
7	Малчин	2494	14.29	99	11.72	4000	20.39	46.39	11.97		92.26
8	Наранбулаг	4266	24.44	90	18.23	5300	27.01	69.67	17.97		339.73
9	Өлгий	2417	13.84	113	12.96	2300	11.72	38.53	9.94		85.54
10	Өмнөговь	4626	26.50	109	23.94	3200	16.31	66.74	17.21		95.38
11	Өндөрхангай	3232	18.51	286	43.88	4700	23.95	86.35	22.28	36.58	163.52
12	Сагил	2463	14.11	61	7.13	3800	19.37	40.61	10.48		54.62
13	Тариалан	4022	23.04	30	5.73	3800	19.37	48.13	12.42	20.39	106.51
14	Түргэн	2150	12.31	36	3.67	2300	11.72	27.71	7.15	11.74	76.09
15	Тэс	5273	30.20	155	38.80	3100	15.80	84.80	21.88		106.68
16	Ховд	2456	14.07	177	20.64	3000	15.29	49.99	12.90		63.37
17	Хяргас	2585	14.81	163	20.00	3400	17.32	52.14	13.45	22.09	123.23
18	Цагаанхайрхан	2061	11.81	226	22.11	4000	20.39	54.30	14.01	23.00	130.84
19	Улаангом	30946	177.26	0.00	0.00	30	0.15	177.42	45.77	75.16	317.69
	НИЙТ ДҮН	82,604	473.17	2705	354.87	69630	354.87	1,182.92	305.17	307.92	2,370.62

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Сангийн сайдын 2017 оны 230 дугаар тушаалаар баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 8.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т зааснаас доошгүй хувь хэмжээгээр сум дүүргийн ОНХС-д хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1 болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилагдсан сум, дүүргийг мөн багтаан тооцно” гэж заасны дагуу ОНХНС-аас олгосон шилжүүлгийг сумдын ОНХС-д хуваарилахдаа алслалт болон газар нутгийн хэмжээнээс тус бүр 30%, хүн амын тооноос 40%-аар хамааруулж тооцсон байна.

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуулиар ОНХНС-аас 5570.7 сая төгрөг санхүүжилт Увс аймагт олгохоор батлагдсан ч гүйцэтгэлээр 262.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн байна. Үүнээс шалтгаалж аймаг, сумдын ОНХС-д олгох санхүүжилтийг дутуу олгосон байна.

Аймаг сумдын ОНХС-д олгосон санхүүжилтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-6 /сая төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас олгосон санхүүжилт			
			Батлагдсан дүн /тодотголоор/	ирсэн санхүүжилт	Зөрүү	Ирсэн санхүүжилтийн хувь
1	Аймгийн ОНХС	68.0	3063.3	2885.09	-178.2	94%
	Аймгийн дүн	68.0	3063.3	2885.09	-178.2	94%
2	Баруунтуруун	0.00	96.3	91.5	-4.8	95%
3	Бөхмөрөн	21.4	104.5	99.3	-5.2	95%
4	Давст	15.86	97.9	93.0	-4.9	95%
5	Завхан	14.50	79.5	75.6	-4.0	95%
6	Зүүнговь	22.30	91.9	87.3	-4.6	95%
7	Зүүнхангай	12.78	110.8	105.3	-5.5	95%
8	Малчин	13.50	75.3	71.5	-3.8	95%
9	Наранбулаг	55.5	197.9	188.0	-9.9	95%
10	Өлгий	6.6	67.0	67.5	0.46	101%
11	Өмнөговь	10.3	89.7	85.2	-4.5	95%
12	Өндөрхангай	26.8	154.4	146.6	-7.7	95%
13	Сагил	3.4	52.9	50.2	-2.6	95%
14	Тариалан	88.5	93.7	89.0	-4.7	95%
15	Түргэн	25.3	61.3	58.3	-3.1	95%
16	Тэс	84.5	106.7	101.3	-5.3	95%
17	Ховд	12.3	63.1	60.0	-3.2	95%
18	Хяргас	60.4	105.5	100.2	-5.3	95%
19	Цагаанхайрхан	77.9	111.1	105.5	-5.6	95%
20	Улаангом	19.6	308.0	308.0	0.0	100%
	Сумдын дүн	571.4	2,067.5	1,983.3	(84.2)	96%
	Урсгал зардал		439.9	439.9	0	100%
	Аймаг, сумдын нийт дүн	639.4	5570.7	5308.4	262.3	95%

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс/

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.2 дахь заалтад “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.9-д “ОНХС-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх суурь зардлыг тухайн жилийн Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн хэмжээнээс хэтрүүлэхгүй” гэж заасныг зөрчин аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь Өлгий сумын ОНХС-ийн санхүүжилтийг аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 тогтоолоор баталсан орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээнээс 0.4 сая төгрөгөөр илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**Бүлэг 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөхдөө
ОНХС-ийн үйл ажиллагааны журмын зарим заалтыг
хэрэгжүүлээгүй, зориулалт бус зардал гаргасан байна.**

**2.1. Өлгий, Сагил, Наранбулаг сумууд иргэдийн санал аваагүй 5
хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөсөн
байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.3-д орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтлан тусгахаар заасан байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах;
- Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөхгүй байх;
- Хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;
- Орон нутгийн дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх;
- Иргэдийн оролцоог хангасан байх;
- Зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр эх үүсвэртэй давхардуулахгүй байх;
- Төслөөр шинээр бий болсон эсхүл сайжруулсан өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой урсгал зардлын тооцоо, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгасан байх;

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2020 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн тэмдэглэл хөтлөн эрэмбэлж Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэгт хүргүүлсэн байна. Сумдын Засаг даргын Тамгын газрын ажлын хэсэг сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой уялдуулан эрэмбэлж ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Увс аймгийн 19 сум 2750.4 сая төгрөгөөр нийт 240 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-7 /сая.төг/

№	Сумын нэр	Төсөл арга хэмжээний	
		тоо	мөнгөн дүн
1	Баруунтуруун	11	96.3
2	Бөхмөрөн	13	178.6
3	Давст	7	106.8
4	Завхан	10	142.3
5	Зүүнговь	8	116.0
6	Зүүнхангай	17	145.8
7	Малчин	11	89.8
8	Наранбулаг	13	290.4
9	Өлгий	13	73.5
10	Өмнөговь	19	99.7
11	Өндөрхангай	10	178.5
12	Сагил	1	60.0

13	Тариалан	16	185.0
14	Түргэн	4	81.3
15	Тэс	11	167.4
16	Ховд	9	80.9
17	Хяргас	6	165.1
18	Цагаанхайрхан	14	154.1
19	Улаангом	47	338.9
Нийт дүн		240	2750.4

Эх сурвалж: /Сумын ИТХ-ын тогтоолууд/

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

- Өлгий сум Ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламж барих ажлыг 30.0 сая
- Наранбулаг сум “Ковш трактор” 90.0 сая, “Сургуулийн сурагчдын урлагийн хувцас” 6.0 сая, “Соёлын төвийн сандал шинэчлэх” 10.0 сая, “Эрүүл мэндийн төвийн эмнэлгийн зориулалтын хатуу эдлэл” 10.0 сая, нийт 116.0 сая төгрөгийн 4 ажил
- Сагил сум “Хаман боогч трактор” 59.5 сая

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй байж, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.



Сагил сумын “Хаман боогч трактор”



Наранбулаг сумын “Ковш трактор”

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулан, 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2019 оны А/11 дугаар захирамжаар ажлын хэсгийг байгуулсан байна.

Дээрх ажлын хэсэг аймгийн ЗДТГ, газар, хэлтэс, албадын 2019 оны ажлыг иргэдэд тайлагнах уулзалт хэлэлцүүлгийн үеэр аймгийн Орон нутгийн хөгжлийн

сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан. Түүнчлэн сум бүрээс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгуулах ажлын саналыг авч нэгтгэн аймгийн ИТХ-ын ээлжит 10, 11 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 2020 онд 91 төсөл арга хэмжээг нийт 3883.2 сая төгрөг санхүүжүүлэхээр анх төлөвлөсөн ба төсвийн тодотголоор 82 төсөл арга хэмжээг нийт 3131.3 сая төгрөг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11/02 дугаар тогтоолоор баталжээ.

2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн бүрдэл хангалтгүй байна.

Увс аймгийн хэмжээнд 2020 онд ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-8 /сая.төг/

№	Аймаг,сумын нэр	Төлөвлөсөн ажил				ХАА-ны журам					
		Өмнөх оноос шилжсэн		Шинэ оны ажил		НТШ		Харьцуулалт		Шууд гэрээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймгийн ОНХС			82	3131.3	4	297.0	53	1,976.4	22	762.9
2	Баруунтуруун			11	96.3			1	20.0	8	60.3
3	Бөхмөрөн	1	5.0	12	173.6			8	151.0	4	19.6
4	Давст	3	8.9	4	97.9	1	70.0	3	20.5	2	2.9
5	Завхан			10	142.3			5	118.7	4	21.2
6	Зүүнговь			8	116.0			4	94.5	4	21.5
7	Зүүнхангай	2	2.4	15	143.4			7	115.0	9	30.1
8	Малчин	1	3.0	10	86.8					10	59.1
9	Наранбулаг	2	47.9	11	242.5	1	95	2	47.9	5	59.0
10	Өлгий			13	73.5			1	13.0	9	63.4
11	Өмнөговь			19	99.7			10	41.1	8	51.6
12	Өндөрхангай			10	178.5			4	87.0	1	4.0
13	Сагил			1	60.0			1	60.0		
14	Тариалан	2	15.5	14	169.5			6	110.5	9	68.7
15	Түргэн	1	50.0	3	31.3			2	70.0		
16	Тэс			11	167.4			6	128.5		
17	Ховд			9	80.9			2	30.0	6	47.8
18	Хяргас			6	65.1	1	100.0	2	33.5	3	31.6
19	Цагаанхайрхан	4	43.0	10	111.1	1	22.9	2	52.6	9	51.6
20	Улаангом	4	72.2	43	266.7			5	91.7	35	226.0
Аймгийн нийт дүн		20	247.9	302	5,633.8	8	584.9	124	3,261.9	148	1,581.3

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба/

ОНХС-ийн эх үүсвэрээр нийт 322 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 280 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалт 8, харьцуулалтын арга 124, шууд гэрээ 148 байгуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг

хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр босго үнийг тогтооно”, тухайн үед мөрдөгдөж байсан Монгол улсын Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолоор шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг байна” гэж заасныг зөрчиж аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн “Орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг хүргэх ажил зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс сэтгүүл хэвлүүлэхээр Ар идэр ХХК-д 37.4 сая, Цахим пресс ХХК-д 18.0, иргэн Б.Золзаяад 18.0 нийт 73.4 төгрөг шилжүүлж шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсэгт “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна”, 28.7.3 дахь зүйлд “энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно”, 28.7.4 дэх зүйлд “хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер гэж үзнэ”, 33 дугаар зүйлийн 33.2.2 дахь зүйлд “техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендэрт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох” гэж заасныг зөрчиж аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 33.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй аймгийн архивын тасагт тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулахдаа шаардлагад нийцсэн 2 оролцогчийн тендерээс хамгийн бага үнэтэйг шалгаруулаагүй зөрчилд албан шаардлага өглөө.



Архивын тасгийн тоног төхөөрөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.19 дэх зүйлд “техникийн тодорхойлолт” гэж захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний техникийн үзүүлэлт, үйлдвэрлэл, үйл ажиллагааны арга, технологи, түүнд тавих технологийн шаардлагыг тодорхойлсон бүрдүүлбэрийг хэлнэ” гэж заасныг зөрчин Тариалан сумын ЗДТГ-т авах PRIUS-20 машины техникийн тодорхойлолтод үйлдвэрлэсэн оныг 2012 гэж заасан байхад 2011 онд үйлдвэрлэсэн автомашин хүлээн авч орон

нутгийн хөгжлийн сангаас 14.9 төгрөг зарцуулсан, 9.98 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бургастай багийн өвс тэжээлийн агуулах засварлах ажлын техникийн тодорхойлолтод заасан өвс хадгалах байр, хашааны хэмжээ материалыг өөрчилсөн зөрчилд албан шаардлага өглөө.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлд “Худалдан авах ажиллагааг тайлагнах” 49.1 дэх хэсэгт “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2 дахь хэсэгт “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс тендерийн хавтаст хэрэгт дараах баримт, бичгүүд дутуу байна.

- ОНӨГ: “Тэс суманд гүний худаг гаргах”- техникийн тодорхойлолт цаасаар
- ОНӨГ: “Хот тохижилт үйлчилгээний газарт хог тээвэрлэх автомашин авах”- техникийн тодорхойлолт цаасаар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл
- ОНӨГ: “Улаангом сумын 10-р баг дахь Мөнх бишрэлт ЭМТ-д тоног төхөөрөмж авах”- үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийг 2 гишүүн, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг 3 гишүүн хөтлөөгүй.
- ОНӨГ: “Түргэн сумын соёлын төвийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл”-үнэлгээний хороо байгуулсан шийдвэр
- Эрүүл мэндийн газар: “Зоонозын төвийн автомашин нийлүүлэх”- үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг
- Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль: “Ширээ сандал нийлүүлэх”- хүлээн авсан акт
- Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль: “Гадна талбайн тохижилт”- хүлээн авсан акт, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж
- Улаангом сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль: “Чөлөөт бөхийн дэвжээ”- үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, мэдэгдэл
- Ховд сум: “Багийн соёлын төвийн дотно засвар тохижилт /Ачит, Шивэр баг/-” үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, багийн гишүүдийн үнэлгээний хуудас нэгтгэл
- Ховд сум: “Эрүүл мэндийн төвд цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат нийлүүлэх”- үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, тендерийн урилга, нээлтийн тэмдэглэл
- Ховд сум: “Сумын төвийн гэр хорооллын худгийг ухаалаг худаг болгох”-үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, тендерийн урилга, нээлтийн тэмдэглэл
- Тэс сум: “150 хүүхдийн дотуур байрны тавилга т/т зөөлөн эдлэл”- Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, хорооны хурлын тэмдэглэл, нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, гишүүдийн үнэлгээний хуудас, гэрээ байгуулах зөвлөмж
- Тэс сум: “Хогийн төвлөрсөн цэг байгуулах”- үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл, үнэлгээний хуудас, нэгтгэл
- Тэс сум: “Соёлын төвийн тайзны хөшиг, тайзны хаалт хийх”- үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, гишүүдийн үнэлгээний хуудас, нэгтгэл, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл
- Тэс сум: “1 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөний тохижилт”-нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, гишүүдийн үнэлгээний хуудас, нэгтгэл, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл
- Завхан сум: “Хөдөө багийн худгийн мотор” –тендерийн нээлтийн тэмдэглэл, үнэлгээний хуудас, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр

- ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл
- Завхан сум: “Пресс өвс бэлтгэх”, “Хогийн цэг цэвэрлэх отвалдах”-тендерийн нээлтийн тэмдэглэл, гишүүдийн үнэлгээний хуудас, гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмж, мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг
 - Завхан сум: “Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт”, “Боловсрол дэд хөтөлбөрөөс сургуулийн шүүгээ”, “ЭМТ-ийн тоног төхөөрөмж”- гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг
 - Баруунтуруун сум: “Хүүхдийн цэцэрлэгийн камержуулалт”- техникийн тодорхойлолт
 - Баруунтуруун сум: “Сумын төвийн багуудын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх”, “Спорт залны тохижилт”, “Баруунтуруун сумын сум дундын эмнэлгийн машин”- гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл
 - Зүүнхангай сум: “Цаг уурын хашаа шинэчлэх”, “Аюулгүй нөөц бүрдүүлэлт”, “ЗДТГ-т автомашин авах”- хүлээн авсан акт
 - Зүүнхангай сум: “Даланбулаг багийн Хүнхэрт худаг гаргах”-техникийн тодорхойлолт, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг, гэрээний биелэлт дүгнэсэн акт
 - Зүүнхангай сум: “Үндэсний бөхийн дэвжээ худалдан авах”, “Спорт заланд гар бөмбөгийн бэлтгэлийн тоног төхөөрөмж”, “Ахмадын байрны дээврийн засвар”- гэрээний биелэлт дүгнэсэн акт
 - Цагаанхайрхан сум: “Хогийн цэгийг хумих, ганга жалгыг дарах”-ажлын даалгавар
 - Цагаанхайрхан сум: “ЕБС-д Лингафоны кабинеттэй болох”- гэрээний биелэлт дүгнэсэн акт
 - Өлгий сум: “Сумын ахмадын холбооны өрөөний тохижилт”, “Хөдөөгийн багт гар хийцийн 6 худаг сэргээн засварлах”, “Хойд хорооллыг ухаалаг худагтай болох”- хүлээн авсан акт
 - Ойрад ХЖТ-"Ойрад" ХЖТ-т автобус авахад дэмжлэг-үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг
 - Биеийн тамир спортын газар: “Тоног төхөөрөмж худалдан авах”- хүлээн авсан акт
 - Биеийн тамир спортын газар: “Унадаг дугуйн холбооны багаж тоног төхөөрөмж авах”- техникийн тодорхойлолт, хүлээн авсан акт

Цаашид ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсгийг мөрдөж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйл 47.4 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэний төлөөллийг оруулаагүй байна. Тухайлбал:

- Ойрад ХЖТ-"Ойрад" ХЖТ-т автобус авахад дэмжлэг- үнэлгээний хороонд иргэний төлөөлөл оруулаагүй
- Давст сум: “Бэлчээрийн усан хангамж сайжруулах”- үнэлгээний хороонд иргэний төлөөлөл оруулаагүй
- Зүүнхангай сум: “Даланбулаг багийн хүнхэрт худаг гаргах”-үнэлгээний хороонд иргэний төлөөлөл оруулаагүй
- Зүүнхангай сум: “Аюулгүй нөөц бүрдүүлэлт”, “ЗДТГ-т автомашин авах”- үнэлгээний хороонд иргэний төлөөлөл оруулаагүй

Цаашид ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг мөрдөж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж болголоо.

2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зориулалт бус зардал гаргасан байна.

Увс аймгийн хэмжээнд 2020 онд аймаг, сумдын ОНХС-ийн 5881.7 сая төгрөгийн эх үүсвэрээр 322 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг гүйцэтгэхээр аймаг, сумын ИТХ-аар баталжээ. Үүнийг аймаг, сум тус бүрээр хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-9 /сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Гэрээ байгуулсан ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	
		тоо	өртөг сая/төг	тоо	Гэрээ ний дүн сая/төг	тоо	Гэрээний дүн сая/төг	Үүнээс дутуу олгосон санхүүжилт		тоо	Гэрээ ний дүн сая/төг	Олгосон санхүүжилт сая/төг	тоо	өртөг сая/төг
								тоо	өртөг сая/төг					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Увс аймаг	82	3131.3	79	2900.2	74	2650.2			5	250.0	85.7	3	95.0
2	Баруунтуруун	11	96.3	9	79.9	8	59.8			1	20.0	14.0	2	16.0
3	Бөхмөрөн	13	178.6	12	147.9	12	147.9						1	8.0
4	Давст	7	106.8	6	91.9	6	91.9						1	13.4
5	Завхан	10	142.3	9	100.8	9	100.8						1	2.4
6	Зүүнговь	8	116.0	8	110.0	7	70.6			1	39.4	35.2		
7	Зүүнхангай	17	145.8	16	143.3	12	93.80			4	49.5	33.8	1	0.7
8	Малчин	11	89.8	10	59.1	10	59.1						1	30.7
9	Наранбулаг	13	290.4	8	179.3	6	131.4			2	47.9	40.0	5	88.5
10	Өлгий	13	73.5	10	76.4	10	76.4	3	2.4				4	27.1
11	Өмнөговь	19	99.7	18	92.7	13	76.5	1	1.0	5	16.2	16.2	1	7.0
12	Өндөрхангай	10	178.5	5	88.7	4	73.7			1	15.0	14.7	5	87.5
13	Сагил	1	60.0	1	59.5					1	59.5	52.0		
14	Тариалан	16	185.0	15	178.5	13	128.4			2	50.1	19.8	1	5.8
15	Түргэн	4	81.3	2	69.6	2	69.6						2	11.3
16	Тэс	11	167.4	6	163.3	4	88.6			2	74.7	47.4	9	92.4
17	Ховд	9	80.9	8	69.7	8	69.7						1	3.09
18	Хяргас	6	165.1	6	154.7	6	154.7							
19	Цагаанхайрхан	14	154.1	12	127.1	10	74.5			2	52.6	31.0	2	27.0
20	Улаангом	47	338.9	40	294.0	39	289.0			1	5.0	3.5	7	21.2
	Нийт дүн	322	5881.7	280	5186.5	253	4506.55	4	3.4	27	679.9	393.26	47	537.08

Эх сурвалж: /Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, анхан шатны баримт/

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр нийт 322 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг 5881.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тухайн шатны ИТХ-аар баталсан ба Тэс сум 53.5 сая төгрөгийн 4, Өлгий сум 30.0 сая төгрөгийн 1, нийт 5 ажлыг сумын ИТХ-аар батлуулахгүйгээр хэрэгжүүлж, нийт 327 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээс 280 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг 5186.5 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 253 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бүрэн, 27 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, 47 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.6 дахь заалтад “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ” гэж заасныг зөрчин ОНХС-ийн эх үүсвэрээс орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 7/01 дугаартай тогтоолоор батлуулаагүй өмнөх оноос шилжих Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 16.6 сая, Теле хяналтын төхөөрөмж 2.0 сая, тайлант оны Соёлын төвийн тайзны хөшиг, тайзны хаалт хийх 12.2 сая, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөний тохижилт 22.6 сая, нийт 4 ажилд 53.4 сая төгрөг
- Өлгий сум Ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламж барих ажилд 30.0 сая төгрөг

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчин ОНХС-ийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Тухайлбал:

- Малчин сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2019 онд бэлтгэсэн 8.3 сая төгрөгийн 1652 боодол өвс хадгалалтын горим алдагдсанаас сумын Засаг даргын хүсэлтийг үндэслэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлт гарч ИТХ-ын тогтоолоор акталсан.
- Улаангом сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд бэлтгэсэн 1.5 сая төгрөгийн 30 уут овъёосны хадгалалтын горим алдагдсанаас сумын онцгой комиссын шийдвэрээр акталж устгасан.

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.



Улаангом сумын овъёос



Малчин сумын өвс

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаал 4.2-т “ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулж үл болно” 4.2.4-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” гэж заасныг зөрчиж буцалтгүй дэмжлэг, тусламж үзүүлсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийг дансаар дамжуулан Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд 24.6 сая төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг
- Улаангом сумын онцгой комиссын шийдвэрээр Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.0 сая төгрөгийн 100 боодол өвсийг 4 иргэний хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй олгосон

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 60 дугаар зүйлийн 60.3.2 дахь заалтад “улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага” гэж заасныг зөрчин төрийн бус байгууллагын зарлагыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийг дансаар дамжуулан Спорт дэд хөтөлбөрийн хүрээнд Хөл бөмбөгийн холбоонд 2.5 сая төгрөгийн дэмжлэг,
- Биеийн тамир спортын газар Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс Спортын дэд хөтөлбөрийн хүрээнд Хөл бөмбөгийн холбоонд 2.4 сая, Үндэсний бөхийн холбоонд 5.0 сая, Дугуйн холбоонд 1.2 сая, Сагсан бөмбөгийн өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээний тамирчдын дэмжлэг 2.0 сая, Өсвөр үеийн Үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 2.0 сая, нийт 12.6 сая төгрөгийн дэмжлэгийг төрийн бус байгууллагад олгосон.

Цаашид дээрх зөрчлийг давтан гаргахгүй, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг албан шаардлага болголоо.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг зөрчин аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн санхүүжилтээс “Эрхзүйн боловсрол” дэд хөтөлбөрийн хүрээнд Цахим хуудас идэвхжүүлэх нэрээр 1000000 төгрөгийн гүйгээ хийгдсэн ч 855993 төгрөг хувь хүнд ашиглагдаж төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.1-т “ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ”, 8.8-д “ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ” гэж заасныг зөрчин Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Өндөрхангай суманд бэлчээрийн худаг 30.0 сая, Тэс сумын 150 ортой дотуур байрны хатуу зөөлөн эдлэл 20.0 сая, Тэс суманд багийн төв барих 80.0 сая, Тэс сумын 10, 11 дүгээр багт мал угаалгын ванн барих, худаг засварлах 25.0 сая нийт 155.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил хийгдэж гүйцэтгэл гараагүй байхад барилгын барьцаа дансанд шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон

цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтад “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчин Улаангом сумын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 1.5 сая төгрөгийн өвс тооллогоор дутагдсаныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын 8.1-т “ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ”, 8.8-д “ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ” гэж заасныг зөрчиж Наранбулаг сум нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгосон санхүүжилт 12.0 сая төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Увс аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 14 хөтөлбөрт 698.2 сая төгрөг зарцуулснаас 422.9 сая төгрөг буюу 60.6 хувийг урсгал зардалд зарцуулсан байна. Дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр харуулбал:

Хүснэгт-10 /сая.төг/

№	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	2020 онд санхүүжих дүн	нийт зарцуулсан санхүүжилт	Үүнээс урсгал зардалд зарцуулсан	Гүйцэтгэгч
1	Орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг хүргэх ажил зохион байгуулах	100.00	100.00	100.00	АЗДТГ-100.0 сая
2	Спортын дэд хөтөлбөрийн санхүүжилт	160.00	141.72	39.70	АЗДТГ-27.2 сая, БТСГ-114.52 сая
3	Боловсролыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилт	100.00	97.27	53.87	АЗДТГ-6.9 сая, БСУГ-54.87 сая, Наранбулаг ЕБС-12.0 сая, Улаангом ЗДТГ-4.5 сая, Номын сан-19.0 сая
4	Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн санхүүжилт	109.00	103.86	23.14	АЗДТГ-90.0 сая, ЭМГ-8.7 сая, Нэгдсэн эм 5.16 сая
5	Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн санхүүжилт	45.26	13.79	13.79	АЗДТГ-6.05 сая, БОАЖГ-7.74 сая
6	Зоорь, Хүлэмж дэд хөтөлбөрийн санхүүжилт	31.00	31.00	15.00	АЗДТГ-15 сая, Улаангом ЗДТГ-16.0 сая
7	Соёл урлагийн салбарын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилт	20.00	19.15	19.15	АЗДТГ-13.72 сая, Ойрад театр-1.18 сая, БСУГ-1.76 сая, музей 1.49 сая, номын сан-1.0 сая
8	Монгол хэл бичгийн хөтөлбөрийн санхүүжилт	8.00	8.00	8.00	БСУГ-8.0 сая
9	Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн санхүүжилт	30.00	30.00	30.00	АЗДТГ-30.0 сая
10	Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөрийн санхүүжилт	70.00	46.43	41.93	АЗДТГ-39.53 сая, Улаангом сумын ЗДТГ-4.5 сая, ГБХЗХГ-2.4 сая
11	"Ахмадыг дэмжих" дэд хөтөлбөрийн санхүүжилт	50.00	50.00	50.00	АЗДТГ-29.5 сая Сумдын ЗДТГ-20.5 сая
12	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр	20.00	20.00	1.54	АЗДТГ-0.5 сая ХХУГ-19.5 сая
13	Эрх зүйн боловсрол дэд хөтөлбөрийн санхүүжилт	20.00	17.01	6.76	АЗДТГ-8.01 сая, Цагдаагийн газар-9.0 сая
14	Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн санхүүжилт	20.00	20.00	20.00	АЗДТГ-15.0 сая, ГБХЗХГ-5.0 сая
Нийт дүн		783.26	698.23	422.88	

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, анхан шатны баримт

Аймгийн ОНХС-аас сүүлийн 3 жилд баталж санхүүжүүлсэн хөтөлбөрийн тоо хэмжээ, төсөвт өртгийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-11 /сая.төг/

Огноо	2018	2019	2020	дүн
Хөтөлбөрийн тоо	12	15	14	41
Төлөвлөсөн санхүүжилт	630.1	852.2	783.3	2265.6
Зарцуулсан санхүүжилт	626.7	807.7	698.2	2132.6
Урсгал зардалд зарцуулсан дүн	388.5	572.5	422.9	1383.9
Урсгал зардалд зарцуулсан хувь	62.0%	70.9%	60.6%	64.9%

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан

Дээрх судалгаанаас харахад 2018-2020 онд давхардсан тоогоор 41 хөтөлбөрт аймгийн ИТХ-аар 2265.6 сая төгрөг баталснаас 2132.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 1383.9 сая төгрөг буюу 64.9 хувийг урсгал зардалд зарцуулжээ.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 1.3-т “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заажээ.

Жил бүр хөтөлбөр нэрийн дор урсгал зардлыг санхүүжүүлж байгаа нь журамд заасан ОНХС-ийн үндсэн зорилготой нийцэхгүй байгаад дүгнэлт хийж цаашид хөрөнгийн зардалд зарцуулахад анхаарч ажиллахыг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны “Журам шинэчлэн батлах тухай” 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно”, 8.6-д “Энэ журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн Төрийн сан дах данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна” гэсэн заасныг зөрчиж Зүүнхангай сум ОНХС-ын хөрөнгөөс 2020 онд 127.1 сая төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсанд зөвлөмж өглөө.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Нягтлан бодох бүртгэлд үнэн зөв байх зарчим баримтална”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дэх хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.8-д “Тухайн байгууллага төлбөрийн хүсэлтийг үндэслэх баримт, хяналтын хуудас (энэхүү журмын 4 дүгээр хавсралтаар баталсан №ТТ-4 маягт)-ны хамт ирүүлэх үүргийг хүлээнэ. Үндэслэх баримтад: Төсвийн ерөнхий менежерийн тушаал, төсвийн задаргааг баталсан хавсралт, баталгаажуулсан цалингийн жагсаалт, товчоо (цалингийн жагсаалт болон товчоон доторх мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн байгууллага хариуцна), **ажил, үйлчилгээ гүйцэтгэх, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээн авсан акт, нэхэмжлэх, бараа материалын орлого, зарлагын баримт** эсхүл өр төлбөр байгааг нотолсон тооцоо нийлсэн акт, жижиг мөнгөн сангийн тайлан, арилжааны банк дахь бэлэн мөнгөний дансны хуулга болон бусад баримт бичиг хамаарна. Хуулийн дагуу тендер шалгаруулж, бэлтгэн нийлүүлэгчийг сонгосон бол Үнэлгээний хорооны шийдвэрийг холбогдох материалд хавсаргаж ирүүлнэ”, 7.13-д “дараах тохиолдолд зарлагын гүйлгээ гаргахыг хориглоно”, 7.13.7-д “Энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд” гэж заасныг тус тус зөрчсөн дараах зөрчлүүдэд албан шаардлага өглөө. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн “Орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг хүргэх ажил зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс сэтгүүл хэвлүүлэхээр Ар идэр ХХК-д 37.4 сая, Цахим пресс ХХК-д 18.0, иргэн Б.Золзаяад 18.0, нийт 73.4 төгрөгийг анхан шатны баримтын бүрдлийг хангуулахгүйгээр зарлагын гүйлгээ хийж шилжүүлсэн. Сэтгүүлийг хүлээн авсан акт байхгүй, орлого авч данс бүртгэлд тусгаагүй,
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн санхүүжилтээс “Соёл урлагийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд иргэн П.Батзаяад “Жангар тууль хэвлүүлэх”-ээр 9.5 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдлийг хангуулахгүйгээр зарлагын гүйлгээ хийж шилжүүлсэн. Уг хөрөнгийг хүлээн авсан акт байхгүй, орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, **хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй**, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу хариуцлага тооцох үндэслэл үүссэн ч тухайн хөрөнгийг захиран зарцуулж 1,2 дугаар гарын үсэг зурж зөрчил гаргасан албан тушаалтнууд ажлаас чөлөөлөгдсөн байна.

2.4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 244.5 сая төгрөгийн 16 нэр төрлийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Нягтлан бодох бүртгэлд үнэн зөв байх зарчим баримтална”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг тус тус зөрчиж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах хөрөнгө оруулалтын ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- Тэс сумын ЗДТГ нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүний худаг,
- Улаангом сумын 12 дугаар цэцэрлэг нь аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 83.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улаангом сумын 12-р цэцэрлэгийн халаалтын тогоо,
- Зүүнговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 17.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн,
- Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр чөлөөлсөн 83.0 төгрөгийн 4, 11 багт байршилтай 4 газар,
- Давст сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 3.0 сая төгрөгийн Гэр хорооллын гудамж талбайн гэрэлтүүлгийн кабель 1500 метр сип утас,
- Өлгий сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 2.0 сая төгрөгийн ахмадын холбооны өрөөний тохижилт, 12.0 сая төгрөгийн хөдөөгийн багт гар хийцийн 6 худаг сэргээн засварлах, 12.9 сая төгрөгийн ухаалаг худаг, нийт 26.9 сая төгрөгийн 8 хөрөнгө оруулалтын ажил,

Дээрх данс бүртгэлд тусгаагүй 244.5 сая төгрөгийн 16 нэр төрлийн хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгахыг албан шаардлага болголоо.



Улаангом сумын газар



Өлгий сумын ухаалаг худаг

Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны “Дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм” болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавихаар заажээ.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/42 дугаар тогтоолоор байгуулсан ОНХС-ийн хяналтын хороо нь тодорхой үр дүнтэй ажил хийгээгүй, тус хорооны дарга болон 3 гишүүний албан тушаал өөрчлөгдсөн тул аймгийн ИТХ-ын даргын 2021 оны А/12 дугаар захирамжаар хяналтын хороог шинэчлэн байгуулсан байна.

Цаашид аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг зөвлөмж болголоо.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй” 69 дүгээр зүйлд төсвийн ерөнхийлөн захирагч дотоод аудиттай байх талаар болон дотоод аудитын чиг үүргийг тусгажээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь ОНХС-ийн 2020 оны зарцуулалтад тусгайлсан хяналт, шалгалт хийгээгүй байна. Харин иргэнээс ирсэн өргөдлийн дагуу Наранбулаг сумын ОНХС-ийн санхүүжилтээр хийгдсэн “Ёслол хүндэтгэлийн өргөө бариулах”, “Ковш трактор худалдан авах” ажлуудыг шалгаж дүгнэлт зөвлөмж гаргаж хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэсэн байна. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхдээ аймгийн ОНХС-аас эрх шилжүүлэн олгосон Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөрийн санхүүжилт 2.4 сая, Залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн санхүүжилт 5.0 сая төгрөгийн зарцуулалтыг хамруулан шалгасан байна. Тус шалгалтаар “12 дугаар ангийн шилдэг төгсөгчдөд бэлэг өгсөн жагсаалтад гарын үсэг дутуу зуруулсан зөрчил”-д зөвлөмж өгсөн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс ковид-19 цар тахлын тархалтын улмаас сумдад очиж ажиллах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул 2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. Харин сумдын 2020 оны ажлыг дүгнэхдээ ОНХС-ын хэрэгжилтийг нэг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн байна.

Цаашид ОНХС-ын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст зөвлөмж болголоо.

3.2. ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.9-т “Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана” гэж заасны дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс сумдын ОНХС-ийн 2020 оны гүйцэтгэл, зарцуулалтын тайланг сум тус бүрээр гаргаж нэгтгэн хүргүүлсэн байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.11-т ОНХС-ийн орлого, зарлага нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийг тухайн аймаг, нийслэлийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэнэ” гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нэгтгэн тайлагнасан байна.

3.3. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-12

№	Зөвлөмжийн утга	Биелэлтийн хувь
1	ОНХС-ийн журамд заасны дагуу мэдээ тайланг холбогдох байгууллагад хүргүүлж байх.	100%
2	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалт хийх Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог байгуулах.	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Эх сурвалж: /Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ/

ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-13

№	Албан шаардлагын утга	Биелэлтийн хувь
1	Тэс сум ахмадын болон халуун усны байрыг нэгдсэн дулаанд холбох ажлыг гүйцэтгэхээр “Шүүдэр гранд” шалгарсан боловч ажлыг гэрээнд заасан хугацаанд бүрэн хийгээгүй байхад санхүүжилтийн 52.6 хувь 20.5 сая төгрөгийг олгосон байна.	Хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа
2	Завхан сум ЗДТГ-ын автомашины мотор худалдан авах 12.0 сая төгрөгийн ажлыг 3 хувааж, сумын төвийн тохижилт, гэрэлтүүлэг, фасад чимэглэл, цэцэгжүүлэлт хийх 40.0 сая төгрөгийн ажлыг 4 хувааж тендер зарлахгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	100%
3	Давст сумын ЗДТГ ус цэвэршүүлэгч төхөөрөмж 9.8 сая, дрон 2.4 сая, мотоцикл 1.8 сая, амралт, аяллын талбай 5.0 сая, ёслол хүндэтгэлийн өргөө 40.0 сая, гудамжны гэрэлтүүлэг 14.9 сая, нийт 73.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
4	Зүүнговь сум “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд” хөтөлбөр нэрээр 5.7 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.	100%
5	Зүүнхангай сум “малын үүлдэр угсаа сайжруулах” ажлын хүрээнд 13.0 сая төгрөгөөр хуц, ухна худалдан авч малчдад үнэ төлбөргүй тараасан байна.	0
6	Зүүнхангай сумын ЗДТГ бэлэн бусаар торгох торгуулийн машин 2.5 сая, өвс тэжээл 7.9 сая, хогийн сав 6.0 сая, контейнер 18.0 сая, худгийн төхөөрөмж 28.0 сая, нийт 62.4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
7	Өлгий сум “Хүүхдийн анхдугаар чуулган зохион байгуулах” үйл ажиллагааны хүрээнд 1.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.	100%
8	Өмнөговь сум “Үүлэнд нөлөөлөх сум” авах ажлын хүрээнд 5.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.	100%
9	Өндөрхангай сум “муур нохой устгах” ажлын хүрээнд 5.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.	100%
10	Улаангом сум “Боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд” хөтөлбөрт 9.0 сая, “Аялал жуулчлалыг дэмжих” хөтөлбөрт 9.0 сая, Хүүхдийн хүчирхийллийн эсрэг-2019” дэд хөтөлбөрт 3.0 сая нийт 21.0 сая төгрөгийг хөтөлбөр нэрээр урсгал зардалд зарцуулсан байна.	100%
11	Улаангом сум 10 дугаар багт “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” 34.9 сая төгрөгийн, 12 дугаар багт “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах” 24.9 сая төгрөгийн ажлуудын техникийн	100%

	тодорхойлолт болон ажлын даалгаврыг тодорхой боловсруулаагүй байна.	
12	Ховд сум “Нийгмийн халамж, асаргааны эмчилгээ хэрэгжүүлэх” үйл ажиллагааны хүрээнд 500.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан байна.	100%
Биелэлтийн дундаж хувь		83.3%

Эх сурвалж: /Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ/

ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн актыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-14

№	Актын утга	Биелэлтийн хувь
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд тив, дэлхий олон улс улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилт гаргасан тамирчид, багш дасгалжуулагчид, спортын мастер, дэд мастер дэд мастерын болзол хангасан тамирчдад 20040.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 2004.0 мянган төгрөгийн ашиг суутгасан боловч орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байсныг төлүүлэх.	100%
2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд аймгийн Засаг даргын нэрэмжит “Авьяас-2019” наадмын зардалд 20000.0 мянган төгрөгийг бэлнээр гаргаж 11530.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд олгосноос 1153.0 мянган төгрөгийн ашиг суутган тооцож орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй байсныг төлүүлэх.	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Эх сурвалж: /Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ/

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-15

№	Албан шаардлагын утга	Биелэлтийн хувь
1	Цагаанхайрхан сум “Халуун усны шугам”-ын 9950.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
2	Өмнөговь сум “Төгрөг хоолын худаг”-т хамгаалалтын байр барих 1200.0 мянга, “Орлого багт өвс тэжээлийн фонд барих” 4000.0 мянга, “Цэцэрлэгийн худаг гаргах” 5000.0 мянга, “Гудамжны хогийн сав худалдан авах” 3000.0 мянга, “Сургуульд ширээ сандал авах” 3000.0 мянга, нийт 16200.0 мянган төгрөгийн ажлуудыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, худалдан авах гэрээнд техникийн тодорхойлолт байхгүй, бараа материалын ширхэг, нэр төрлийг тусгаагүй байхад ажлын гүйцэтгэлийг үнэлж, үе шаттайгаар санхүүжүүлэхгүйгээр гүйцэтгэгч талуудад санхүүжилтийг бүрэн олгож санхүүгийн тайлант авлагаар тусгасан байна.	100%
3	Тэс сум “Соёлын төвийн тайзны хөшиг, тайзны хаалт” 12190.8 мянган төгрөг, “Теле хяналтын төхөөрөмж” 9110.0 мянган төгрөг, нийт 21300.8 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Эх сурвалж: /Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ/

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн актыг дараах байдалтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт-16

№	Актын утга	Биелэлтийн хувь
3	Бөхмөрөн сум “Сумын төвд авто зогсоол, гэрэлтүүлэг хийх ажил”-ын хүрээнд зураг төсвийн санхүүжилтийг гэрээний үнийн дүнгээс 1587.5 мянган төгрөгөөр илүү олгосныг нөхөн төлүүлэх.	100%
Биелэлтийн дундаж хувь		100%

Эх сурвалж: /Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ/

ДҮГНЭЛТ

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан ч Өлгий суманд 0.4 сая төгрөг илүү шилжүүлсэн байна.
2. Өлгий, Сагил, Наранбулаг сумууд иргэдийн санал аваагүй 5 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-аас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.
3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хавтаст хэргийн бүрдэл хангалтгүй байна.
4. Ойрад хөгжимт жүжгийн театр, Зүүнхангай, Давст сумууд тендерийн үнэлгээний хороонд иргэний төлөөлөл оруулаагүй байна.
5. Тэс сум 53.4 сая төгрөгийн 4 ажил, Өлгий сум 30.0 сая төгрөгийн 1 ажлыг орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлахгүйгээр ОНХС-аас санхүүжүүлсэн байна.
6. Зүүнхангай сум ОНХС-ын хөрөнгөөс 2020 онд 127.1 сая төгрөгийг шийдвэргүйгээр зарцуулсан байна.
7. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс аймгийн Засаг даргын тамгын газар сэтгүүл хэвлүүлэхэд 73.4 сая, Жангар тууль хэвлүүлэхэд 9.5 сая, Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд 24.6 сая, Спорт хөтөлбөрийн хүрээнд 2.5 сая, цахим хуудас идэвхжүүлэхэд 0.8 сая, Биеийн тамир спортын газар Спорт хөтөлбөрийн хүрээнд 12.6 сая, Малчин сум 8.3 сая төгрөгийн 1652 боодол өвс, Улаангом сум 1.5 сая төгрөгийн 30 уут овъёос, 2.5 сая төгрөгийн 492 боодол өвс, нийт 135.7 сая төгрөгийн хөрөнгийг хууль тогтоомж зөрчиж үр ашиггүй зарцуулсан байна.
8. ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 16 нэр төрлийн 244.5 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
9. Увс аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс нь ОНХС-ын үйл ажиллагааны журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.
10. ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Холбогдох байгууллагын санал



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/Факс: 7045-2113

Цахим шуудан: info@khural.uv.gov.mn

Цахим хуудас: www.uvs.khural.mn

2021.07.06 № 296

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ЕРӨНХИЙ АУДИТОР
М.БАТСУУРЬ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Уг тайланд 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан ажил, үйлчилгээнээс төсөв нь татагдсан, Улсын комисс ажилласан боловч санхүүжилт авч чадаагүй, барилга угсралтын ажлаа дуусгах байсан ч дуусгаж чадаагүй барилгуудын талаар төсөлд тусгаагүй байна. Иймд эдгээр ажлуудыг нэр зааж тусгуулах саналтай. Зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын бусад тайлантай санал нэг байна

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ДАМДИНСҮРЭН



МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-2315, Факс: 7045-4095

Цахим шуудан: info@uvs.gov.mn

Цахим хуудас: www.uvs.gov.mn

2021. 08. 07 № 1/1045

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны
хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах
болно.

ДАРГА



Ч.ЧИМЭД

D disk: AZDTG- zasag A-5

8521020672



УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-3232

2021.07.06 № 101

танай _____-ны № _____-т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны
хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар өгсөн
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Е.МӨНХЗУЛ

D/Албан бичиг/ A5.docx

8521070103

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал: “Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Уг тайланд 2020 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр батлагдсан ажил, үйлчилгээнээс төсөв нь татагдсан, Улсын комисс ажилласан боловч санхүүжилт авч чадаагүй, барилга угсралтын ажлаа дуусгах байсан ч дуусгаж чадаагүй барилгуудын талаар төсөлд тусгаагүй байна. Иймд эдгээр ажлуудыг нэр зааж тусгуулах саналтай. Зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын бусад тайлантай санал нэг байна” гэсэн санал ирүүлсэн байна.

Хариу: ОНХС-ийн үлдэгдэл санхүүжилтийг татан төвлөрүүлдэггүй ба аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас Өндөрхангай суманд бэлчээрийн худаг 30.0 сая, Тэс сумын 150 ортой дотуур байрны хатуу зөөлөн эдлэл 20.0 сая, Тэс суманд багийн төв барих 80.0 сая, Тэс сумын 10, 11 дүгээр багт мал угаалгын ванн барих, худаг засварлах 25.0 сая, нийт 155.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ажил хийгдэж гүйцэтгэл гараагүй байхад барилгын барьцаа дансанд шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Тайлангийн 17 дугаар хуудаст тодорхой оруулсан байна. Улсын комисс ажилласан ч ОНХС-аас санхүүжилт авч чадаагүй, барилга угсралтын томоохон ажил байхгүй бөгөөд Өмнөговь сумын 1 ажилд 1.0 сая, Өлгий сумын 3 ажилд 2.4 сая, нийт 4 ажилд 3.4 сая төгрөг дутуу олгосныг тайлангийн 21 дүгээр хуудасны 9 дүгээр хүснэгтэд тусгасан байна.

2. Аймгийн Засаг дарга: “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зөвлөмжийг цаашид хэрэгжүүлж ажиллах болно” гэсэн санал ирүүлсэн байна.

Хариу: Тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

3. Орон нутгийн өмчийн газар: “Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно” гэсэн санал ирүүлсэн байна.

Хариу: Тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны
хөрөнгийн зарцуулалт

Увс аймаг дахь Төрийн
аудитын газар

ЗӨВЛӨМЖ

Увс аймгийн ИТХ-ын дарга Ц.Батболдод:

1. Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах.

Увс аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга Н.Цогт-Очирт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Мөнхзулд:

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсгийг мөрдөж тендерийн хавтаст хэргийг бүрэн бүрдүүлж, хяналт тавьж ажиллах.

Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгсбаяр, Зүүнхангай сумын Засаг дарга Б.Батсайхан, Давст сумын Засаг дарга Ч.Тогтохбаяр нарт:

1. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийг мөрдөж тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэний төлөөллийг оруулах.

Зүүнхангай сумын Засаг дарга Б.Батсайханд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг сумын Засаг даргын захирамжийг үндэслэн зарцуулах.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



/ М.БАТСУУРЬ /

/ М.БАТ-АМГАЛАН /

/ Б.АВИРМЭД /

/ А.НАНЖИДМАА /

/ Р.АЮУШ /